

## ТҮРЭГ ХЭЛТЭН АРД ТҮМНҮҮД

М. Хурметхан\*

Алтай овгийн хэлээр ярилцдаг ард түмнүүд түрэг, монгол, манж хамниган хэмээх гурван томоохон хэсэгт хуваагддаг. Турк, азербайжан, казах, узбек, уйгур, туркмен, татар, кыргыз, саха гэх мэт түрэг хэлтэн ард түмэн Турк улсаас Номхон далай хүртэлх өргөн уудам нутагт тархсан байна. Тэд Турк, Азербайжан, Казах, Узбек, Кыргыз, Турк мөн улс, Татар, Башхурт, Алтай, Саха, Иран, Афганистаны хойд хэсэг, Дорнод Туркестан, Монгол улсын баруун хэсгээр нутагладаг билээ. Түрэг хэлээр ярьдаг ард түмнүүдийн хэл, түүх, утга зохиол, соёл нийтлэг юм. Түрэг хэлтэн ард түмнүүдийн тухай Орхоны бичээс, эртний уйгур бичээс, дундад зуунд бичигдсэн түрэг, Хятад, Монгол, араб, перс хэл дээрх сурвалж бичгүүдэд тодорхой мэдээлэл бидэнд уламжлагдан иржээ. Ялангуяа Махмуд Хашгари, Мухаммед Хайдар Дулати, Кыдыргали Жалаири, Рашид-ад-Дин нарын бүтээл нь эх хэлтэн ард түмнүүдийн угсаа гарваль, түүхийн ихээхэн үнэ цэнэтэй зүйлийг бидэнд хүргэсэн юм. Дэлхийн олон улс оронд түрэг хэлтэн ард түмнүүдийг судлах ажил XX зууны эхээс хүчтэй болж өргөн хэмжээгээр хийгдэж ирсэн бөгөөд хийгдэж байна. Дэлхийн шинжлэх ухаанд Түрэг судлал хэмээх салбар бий болон хөгжив. Түрэг судлалын хүрээнд түрэг хэлтэн ард түмэн тус бүрийн талаар багагүй судалгаа хийжээ. Сүүлийн жилүүдэд дэлхийн түрэг судлал шинэ агуулгаар баяжиж түрэг хэлтэн ард түмнүүдийн түүх, соёлд шинэ сэтгэлгээгээр хандах болов. Өнөөгийн байдлаар нийт түрэг хэлтэн ард түмнүүдийн хүн амын тоо 135 саяас давж байна. Баруун хойд Европ, Зүүн өмнөд Азийг холбож ирсэн түрэг хэлтэн ард түмнүүдийн бүслүүр нь гарал үүсэл, хэл, оюуны соёлын хувьд тэс өөр хятад, оросын түрэмгийллийн улмаас хэд хэдэн газраар тасарсан юм. Түүний улмаас түрэгийн ертөнц тал бүрийн түүхэн нийтлэг байдлаа алдахад хүрсэн байна. Нийт тоо нь 40 хүрэх түрэг хэлтэн ард түмний хорь нь ирээдүйд тусгаар тогтносон төр улсаа байгуулах боломжтой юм. Өнөөгийн хэвийн байдал хадгалагдвал ирээдүйд дэлхийн түрэг хэлтэн ард түмнүүдийн хүн ам 300 саяас хол давах юм. Өнөөдөр тусгаар тогтносон түрэг хэтэн улсуудын эгнээнд Турк улсын хамт Узбек, Казах, Азербайжан, Туркмен, Кыргыз улс багтан орлоо.

Түрэгийн ертөнц нь арабын ертөнцтэй адил том байвч (газрын хэмжээ тэнцүү 14 сая км<sup>2</sup>, хүн ам нь 140 сая ба 240 сая) түүний улс төрийн тусгаар тогтнол, улс төрийн нэгдэл хангагдаагүй хэвээр байна. Арабын 21 орчим улс тусгаар тогтносон, НҮБ-ын гишүүн байгаа бол харин түрэгийн улсууд тусгаар тогтнолоо (Турк улсыг үл тооцвол одоо л олж авч байна. Дээр дурдсан таван түрэг хэлтэн залуу төр улсын тусгаар тогтнол нь бүрэн төгс хангагдаж дуусаагүй байна. Гэлээ ч түрэг хэлтэн тусгаар тогтносон улсууд 6, үндэсний бүгд найрамдах улс (одоо ТТУХН-д 13) болон үндэсний мужуудын (бусад оронд 7) эрх зүйн хэмжээ дээшилж байна.

М. Хурметхан. ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд эрдэмтэн

ДЭЛХИЙН ТҮРЭГ ХЭЛТЭН АРД ТҮМНҮҮДИЙН  
НИЙТ ТОО  
(1992 оны дундуурхи тоо)

Үндэстэн	Тоо
1. Турк	57,0 сая
2. Узбек	19,8 сая
3. Азербайжан	16,2 сая
4. Казах	10,5 сая
5. Уйгур	7,9 сая
6. Татар	7,2 сая
7. Туркмен	4,7 сая
8. Кыргыз	3,0 сая
9. Чуваш	1,9 сая
10. Башхурт	1,6 сая
11. Кырамчууд	790 мян,
12. Кашкай	785 мян.
13. Кызылбас	630 мян.
14. Карахалнак	475 мян.
15. Саха	400 мян.
16. Апшар	390 мян.
17. Шаксыбан	320 мян.
18. Кумык	315 мян.
19. Тува	250 мян.
20. Мескет	225 мян.
21. Гагауыз	223 мян.
22. Карата	170 мян.
23. Кыпырчууз	155 мян.
24. Карапапак	105 мян.
25. Малкар	100 мян.
26. Салар	95 мян.
27. Хакас	93 мян.
28. Ногай	90 мян.
29. Алтайчууд	85 мян.
30. Бухарын Еврей	40 мян.
31. Каджар	38 мян.
32. Урианхай	30 мян.
33. Карадаг	25 мян.
34. Шор	20 мян.
35. Шар уйгур	14 мян.
36. Долган	7 мян.
37. Хотанчууд	5 мян.
38. Карайым	4 мян.
39. Кырымчакууд	2 мян.
40. Топа	1 мян.

Дэлхийн түрэг хэлтэн ард түмнүүдийн нийт тоо 135 сая 628 мянга